# МОНГОЛ УЛС
# БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 13 өдөр Дугаар 01/487 Номгон

"Нээлттэй Баянхонгор" нэгдсэн арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх, Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол малчин" үндэсний хөтөлбөр, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.3 дахь, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.6.3 дахь, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай" тогтоолын хавсралтын 1.7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Алслагдсан сум, багийн малчдад зориулсан "Нээлттэй Баянхонгор" нэгдсэн арга хэмжээний хүрээнд "Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган"-ыг зохион байгуулсугай.

2.Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, удирдамжийг хоёрдугаар, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гуравдугаар, зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Арга хэмжээг зохион байгуулахад зарцуулагдах 35 000 000 (гучин таван сая) төгрөгийг аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)- д зөвшөөрсүгэй.

4.Арга хэмжээнд 20 сум 105 багийн малчид, тариаланчид, аж ахуй эрхлэгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэгчдийн төлөөллийг оролцуулан өндөр хэмжээнд зохион байгуулж, удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Батсуурь)-д, удирдамжийн дагуу холбогдох салбарын төлөөлөгчдийн оролцоог ханган ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А/181 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн ахлагч : Б.Батсуурь - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Т.Норов-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

Д.Энхжаргал- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

П.Отгонбаяр-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Т.Хишигбаатар-Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

С.Байгалмаа-Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Д.Сарангарав-Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Г.Нэмэхбаяр-Цэргийн штабын дарга

В.Наранчимэг-Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Г.Энхбаяр-Баянхонгор сумын Засаг дарга

Б.Оюунбаатар-Биеийн тамир, спортын газрын дарга

Н.Энхжаргал-Эрүүл мэндийн газрын дарга

Д.Алтангэрэл-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Л.Оюун-Эрдэнэ-Мал эмнэлгийн газрын дарга

Ж.Уламбаяр-Баянхонгор Эрчим хүч ЦТХК-ийн захирал

Д.Мөнхцэцэг-Соёл, урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Пүрэвдагва-Хөгжимт драмын театрын дарга

Н.Одончимэг-Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Цэрэнханд-Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: У.Балжинням-Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....................оОо........................

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын
13-ны өдрийн А/467 дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт

# "НЭЭЛТТЭЙ-БАЯНХОНГОР" АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ

**Нэг. Үндэслэл**

Баянхонгор аймаг нь 116 мянган км газар нутагтай, 20 сум, 105 баг, 26737 өрх, 89643 хүн амтай, үүнээс 13000 малчин өрх 3.7 сая толгой малтай нийт хүн амын 25 хувь нь малчин өрх байна.

Газар нутаг нь говь, хангай, тал хээр хосолсон гурван бүсийн нутагтай учир газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй зэрэг хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж байгаа ба үүнээс аймаг орон нутгийн эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх салбар болсон мал аж ахуйн салбарт хувь нэмрээ оруулан ажиллаж буй малчид нь мал аж ахуйг эрхлэхээс гадна нэг талаасаа үйлдвэрлэгчид, нөгөө талаасаа ажил олгогчид юм.

Иймд үйлдвэрлэгч-малчдынхаа үйлдвэрлэл, бизнесээ таатай орчинд явуулах, үр ашгаа шударга зарчим, шударга хуваарилалтаар хүртэж сайхан амьдрах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах.

**Хоёр. Зорилго**

Төр засаг, аймаг, орон нутгийг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд хөдөө аж ахуйн салбар, малчдын талаар тусгагдсан бодлого шийдвэрийн хэрэгжилтийн мэдээллийг өгөх, малчдын санал хүсэлтийг сонсох, арга туршлагыг солилцох, цаашид малчдын талаар авч хэрэгжүүлэх орон нутгийн бодлогыг тодорхойлох, малчдын урлаг, спортын авьяас чадварыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, биеийн тамир спортоор нөхөрлөх, малчдын оролцоо хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

**Гурав. Зохион байгуулагдах үйл ажиллагаа, арга хэмжээ, хамрах хүрээ**

3.1."Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган" зохион байгуулах

3.2.Малчдын дунд соёл урлагийн арга хэмжээ, уралдаан

3.3.Малчдын дунд спортын 7 төрөлт тэмцээн

3.4.Эмчийн үзлэг

3.5.Сумдаас **"Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган"-д** оролцох бүрэлдэхүүн:

Ш сум тус бүрээс удирдах ажилтан-1, нийт 45-50 малчин үүнээс эрэгтэй 25 эмэгтэй 25 малчин

Ш 18-35 насны малчин үүнээс: эрэгтэй 6 эмэгтэй 6

Ш 36-45 насны малчин үүнээс: эрэгтэй 6 эмэгтэй 6 малчин

Ш 46-55 насны малчин үүнээс: эрэгтэй 6 эмэгтэй 6 малчин

Ш 56-аас дээш насны малчин үүнээс: эрэгтэй 7 эмэгтэй 7 тус тус оролцоно.

3.6. **"Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган"**-ы үйл ажиллагаанд сумдаас ирсэн 45-50 малчин, удирдах ажилтны хамт бүрэлдэхүүнээрээ оролцоно.

## Дөрөв. Зохион байгуулах арга хэмжээний хугацаа, газар, хариуцах байгууллага

| № | Үйл ажиллагаа, арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Зохион байгуулах газар | Зохион байгуулагдах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | "Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган"-ы нээлтийн үйл ажиллагаа | 2023.09.22 | Аймгийн ЗДТГ | Төв цэнгэлдэхэд | 09.00-10.00 |
| 2 | "Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган" | 2023.09.22 | | Усан бассейн спорт цогцолборт | 10.00-13.00 |
| 3 | Хүндэтгэлийн шоу цэнгүүн | 2023.09.22 | Соёл урлагийн газар | Баганат талбай | 20.00-23.00 |
| 4 | Эмчийн үзлэг | 2023.09.22-24 | Эрүүл мэндийн газар | Угалз 4-р багийн заал | 09.00-18.00 |
| 5 | Соёл урлагийн арга хэмжээ, уралдаан | 2023.09/22-24 | Соёл урлагийн газар | -Хөгжимт драмын театр<br>-Тэмүүжин театр | 2023.09.22-ны 14.00-18.00 |
| | | | | | 2023.09.23-ны 09.00-18.00 |
| | | | | | 2023.09.24-ны 09.00-13.00<br>-Гала тоглолтын бэлтгэл 14.00-17.00 |
| 6 | Спортын 7 төрөлт тэмцээн | 2023.09.22-24 | Биеийн тамир спортын газар | -Усан бассейн спорт цогцолбор<br>-Спорт хороо<br>-Үндэсний сурын талбайд<br>-Цагаан чулуут | 09.00-18.00 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | | 5.6-р багийн заал -Эрдэнэ мандал 2-р багийн заал | |
| 7 | "Нүүдэлчин фестиваль"-д оролцсон Шашин урлагийн цэнгүүн | 2023.09.23 | Соёл урлагийн газар | Баганат талбай | 18.00-22.00 |
| 8 | Хаалтын үйл ажиллагаа-"Гала тоглолт" | 2023.09.24 | Соёл урлагийн газар | Баганат талбай | 19.00-23.00 |

**Тав. Соёл урлагийн арга хэмжээ**

**5.1. Уралдааны төрөл:** Монгол Улсын биет бус соёлын өвийн төлөөллийн үндэсний бүртгэл (7 ай сав)-д заасан дараах аман илэрхийлэл, язгуур урлагийн төрөл зүйлээс бүрдэнэ.

Уртын дуу - (1 малчин)

Ардын богино дуу - (1 малчин)

Харилцаа дуу - (2 малчин)

Хамтлаг дуу - (4 малчин)

Домог, шог хошин яриа, элэглэл, онигоо - (1 малчин)

Ардын бүжиг, бий биелгээ - (1-3 малчин)

Ардын хөгжим - (1 малчин)

Исгэрээ, тагнай ташилт, хөөмий, хоолойн лимбэ (өгүүлэхүйн эрхтний шүтэлцээт урлаг) - (1 малчин)

Аман аялгуу, цол дуудлага, аялгуут үгс, аялгуут үлгэр (аман уламжлалын илэрхийлэл) - (1 малчин)

Ерөөл, магтаал - (1 малчин)

Хөдөлмөр, зан үйлийн холбогдолтой уриа дуудлага - (1 малчин)

**5.2.Уралдаанд оролцогчдын баримтлах зарчим**

Ил тод, нээлтэй байх

Тэгш оролцоог хангах

Чанар, хүртээмжтэй байх

**5.3.Уралдааны хамрах хүрээ, зохион байгуулалт**

Уралдаанд сум тус бүрээс 15-20 малчны бүрэлдэхүүнтэй нэг баг оролцоно.

Спортын төрөлд оролцож буй малчид давхардаж оролцохгүй.

Баг нь уралдааны төрлүүдийг багтаасан нүүдлийн ахуй, уламжлалыг харуулж, жүжигчилсэн тоглолтыг 30 минутад үзүүлнэ. Тоглолтын хуваарийг Соёл, урлагийн газраас гарган хүргүүлнэ.

Техникийн зөвлөгөөнийг 2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 16:00 цагт Хөгжимт драмын театрт зохион байгуулна. /Сумын удирдлага заавал оролцоно/

Шүүлтийг 1-20 оноо өгөх ба бага онооны зарчмаар зохион байгуулагдана.

Оролцогч сум удирдамжид заасны дагуу тоглолтын хугацаа, ая, хөгжим, хувцас тайзны хэрэгслээ урьдчилан бэлтгэсэн байна.

Шүүгчдийн шийдвэр нь эцсийнх байх бөгөөд маргаан гаргасан тухайн төрөлд 20 оноо өгнө. /бага онооны системээр/

**5.4.Уралдааныг дүгнэх журам**

1. Уралдааныг мэргэжлийн шүүгчдийн бүрэлдэхүүн шүүж, дүгнэнэ.

2.Үзүүлбэр тус бүрд гүйцэтгэл, хувцаслалт, зохион байгуулалт зэргийг харгалзан бага онооны зарчимд тулгуурлан 1-20 оноо өгөх ба төрөл тус бүрийн онооны нийлбэрээр багийн урлагийн дүн гарна. /оролцсон баг бүр зохих оноог авч эцсийн дүнд нөлөөлнө/

**3.** Сумдын шагналт байранд шалгарсан шилдэг, онцгой, өвөрмөц, мартагдсан үзүүлбэрээр нэгдсэн хаалтын Гала тоглолтыг зохион байгуулна.

Жич: Соёл урлагийн газар нь гүйцэтгэл, зохион байгуулалтыг харгалзан шилдэг "Соёлын төв"-ийг шалгаруулан шагнаж, урамшуулна.

**Зургаа. Спортын төрлийн зохион байгуулалт, хамрах хүрээ**

| № | Спортын төрөл | Тэмцээн болох газар | Тэмцээн эхлэх өдөр цаг | Оролцох хүний тоо, насны ангилал | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Холимог волейбол | -Спорт цогцолбор -Спорт хороо | 2023.09. 22-ны 14.00-18.00<br>2023.09. 23-ны 09.00-18.00<br>2023.09. 24-ны | 18-35 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 36-42 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 43-49 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 Сэлгээний эрэгтэй-1, | С.Идэрбаясгалан 92010 140 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|
| | | | 14.00 | эмэгтэй-1 тамирчин | |
| 2 | Софт волейбол | 5.6-р багийн заал, 2-р багийн заал | 2023.09. 22-ны 14.00-18.00<br>2023.09. 23-ны 09.00-18.00<br>2023.09. 24-ны 09.00-14.00 | 50-55 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 56-аас дээш нас эрэгтэй-1, эмэгтэй-1 Сэлгээний эрэгтэй-1, эмэгтэй-1 тамирчин | М.Энхзаяа 80206100 |
| 3 | Ширээний теннис | Спорт цогцолбор | 2023.09. 23-ны 09.00-18.00<br>2023.09. 24-ны 09.00-14.00 | эрэгтэй-1, эмэгтэй-1 тамирчин | О.Загдсүрэн 88809933 |
| 4 | Хөгжөөнт буухиа | Спорт цогцолбор | 2023.09. 23-ны 14.00 - 18.00 | 18-35 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 36-42 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 43-49 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 50-54 нас эрэгтэй-1, эмэгтэй-1 55 наснаас дээш эрэгтэй-1, эмэгтэй-1 тамирчин | Д.Арцад 88190598 |
| 5 | Дартс | Спорт цогцолбор | 2023.09. 22-ны 14.00 - 18.00 | эрэгтэй-1, эмэгтэй-1 тамирчин | Н.Отгонбаяр 89891606 |
| 6 | Байт харваа | Үндэсний сурын талбайд | 2023.09. 23-ны 13.00 - 18.00 | эрэгтэй-1, эмэгтэй-1 тамирчин | Б.Мөнх-эрдэнэ 89303797 |
| 7 | Шагай наадгай: Шүүрэх | Спорт цогцолбор | 2023.09. 23-ны 09.00-13.00 | эрэгтэй-1 тамирчин | Т.Гомбо 88089755 |
| | Няслах | | | эмэгтэй-1 тамирчин | |
| | Морь | | | эрэгтэй-1, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | уралдах | | | эмэгтэй-1 тамирчин | |

**Долоо. Спортын төрөлд оролцох журам**

7.1.Тэмцээнд оролцох тамирчид өөрийн нутаг дэвсгэрт байрлах сум багийн харьяаллын өмнөөс давхардал үүсгэхгүйгээр спортын 1-2 төрлийг сонгон оролцоно.

7.2.Холимог волейболын тэмцээнд оролцож байгаа сэлгээний тамирчид өөрийн насны үндсэн тамирчнаар солилцоо хийж болно.

7.3. Багууд сум, багийн таних тэмдэгтэй жигдэрсэн хувцастай байна.

7.4.Баг, тамирчдыг тухайн спортын төрлүүд эхлээд тамирчны нэр, багийг зарласнаас хойш 10 минут хүлээгээд талбайд гараагүй тохиолдолд тухайн тоглолтын хожлыг эсрэг баг, тамирчинд олгоно.

7.5.Багийн оролцох тооноос хамаарч тоглолтын системийг техникийн зөвлөгөөн дээр ярилцана.

7.6.Спортын төрөлд оролцох тамирчдын мэдүүлгийг хавсралтаар Хүнс, хөдөө аж ахуйн газарт 2023 оны 09 дүгээр сарын 18-ны дотор ирүүлсэн байна.

**Найм. Тэмцээний шүүгчийн бүрэлдэхүүн**

8.1.Тэмцээнийг Биеийн тамир, спортын газраас томилогдсон шүүгч нар шүүж явуулна.

8.2.Тэмцээнтэй холбоотой санал гомдлыг бичгээр тэмцээний ерөнхий шүүгчид гаргаж болно.

**Ес.Чуулганы нэгдсэн дүн гаргах, дүгнэх**

9.1.Сумдын нэгдсэн дүнг гаргахдаа дараах үзүүлэлтүүдийг 1-20 хүртэл оноогоор бага онооны системээр дүгнэнэ. Үүнд:

9.1.1.Цаг баримтлал /1-20 оноо/

9.1.2.Оролцоо, бүрэлдэхүүнд: а.малчин өрхийн оюутан, суралцагч, мал бүхий иргэн оролцуулахгүй

б.ХАА-н салбар дээр бодитоор ажиллаж амьдардаг малчныг оролцуулна.

в.Удирдамжийн 9.1.2.а-г зөрчсөн тохиолдолд тухайн оролцогчийн багийг оролцож буй төрлөөс багаар нь хасна. /1-20 оноо/

9.1.3.Дэг журам, сахилга бат /1-20 оноо/

9.1.4.Хувцас жигдрэлт- эдгээрийн нийлбэр дүн

9.2.Спортын 7 төрөлт тэмцээний нийлбэр дүн /1-20 оноо/

9.3.Урлагийн арга хэмжээний нийлбэр дүн /1-20 оноо/

9.4.Дээрх 3 үзүүлэлтийн нийлбэр дүнгээр 1-5-р байр эзлүүлж шалгаруулна.

9.5.Урлаг, спортын төрөл тус бүрд 1-3-р байрт шалгарсан оролцогчдыг медаль, өргөмжлөлөөр тус тус шагнаж урамшуулна.

9.6.Шагналын сан: Багийн нийлбэр дүнгээр:

1-р байр 1-Өргөмжлөл, мөнгөн шагнал-20 000 000 төгрөг

2-р байр 1-Өргөмжлөл, мөнгөн шагнал-15 000 000 төгрөг

3-р байр 1-Өргөмжлөл, мөнгөн шагнал-10 000 000 төгрөг

Тусгай байр 1-Өргөмжлөл, мөнгөн шагнал-5 000 000 төгрөг

Тусгай байр 1-Өргөмжлөл, мөнгөн шагнал-5 000 000 төгрөг

**Арав.Чуулганд оролцогчдын мэдээлэл ирүүлэх тухай**

10.1. Урлаг, спортын арга хэмжээнд оролцож байгаа малчин нь урлагийн 1-2 төрөл, спортын 1-2 төрөлд оролцох ба урлаг, спортын төрөлд давхцаж оролцохгүй.

10.2.Сумдын ЗДТГ- нь чуулганд оролцох малчдын мэдээллийг нэгдүгээр, урлагийн төрөлд оролцох малчдын мэдээллийг хоёрдугаар, спортын төрөлд оролцох тамирчдын мэдээллийг гуравдугаар хавсралтаар тус тус /оролцох малчин тус бүрийн малчны иргэний үнэмлэхийн хуулбар, e.mongolia-аас "А" дансны лавлагаа/ нэгтгэн 2023 оны 09 дүгээр сарын 18-ны дотор Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлсэн байна.

Жич: 1.Заасан хугацаанаас мэдээлэл хоцроосон сумдын малчдыг чуулган, урлаг, спортын арга хэмжээнд оролцуулахгүй.

2.Мэдээлэл нэгтгэгдэж, арга хэмжээ зохион байгуулагдах газруудад хүргэгдсэн өдөр буюу 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс хойш урлаг, спортын арга хэмжээнд оролцох малчдын мэдээлэл, нэрийг өөрчилж, солих боломжгүйг анхаарна уу.

10.3.Чуулганы талаар мэдээлэл тодруулах утас: Чуулган-88062336, 99066330, урлаг-89864646, спорт-88190598, 88089755

__________oOo__________

Аймгийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн А/187 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

## "НЭЭЛТТЭЙ БАЯНХОНГОР" АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛТГЭЛ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зохион байгуулах ажил, арга хэмжээ | Бэлтгэл ажлууд | Бэлтгэл ажил хангагдах хугацаа | Хариуцах хэлтэс, агентлаг, байгууллага |
|---|---|---|---|---|
| 1 | "Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган"-ы нээлтийн үйл ажиллагаа | Нээлтийн хөтөлбөр бэлтгэх, хянуулах | IX/13 | Соёл урлагийн газар |
| 2 | | Нээлтэд жагсах сумдын туг далбаа, файз бэлтгэх | IX/18 | 1.Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, 2.Хүнс хөдөө аж ахуйн газар |
| 3 | | Нээлтийн зураглал, жагсаалын хайрцаг, орolt гаралт бэлтгэх, жагсах талбайг хуваарилах, сумдад мэдээлэл хүргэх | IX/18 | 1.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, 2.Нийгмийн бодлогын хэлтэс |
| 4 | | Спорт цогцолборын орох гарах хаалгыг хуваарилах | | |
| 5 | | Төв цэнгэлдэхэд тайз, индэр, техник хэрэгсэл бэлтгэх | IX/20 | 1.Соёл урлагийн газар /Хөгжимт драмын театр, Тэмүүжин театр/ 2.Биеийн тамир спортын газар |
| 6 | | Төв цэнгэлдэхийн цэвэрлэгээ үйлчилгээ хийх | | 1.Баянхонгор сум, 2.Биеийн тамир спортын газар |
| 7 | | Нээлтийн үйл ажиллагаанд сумдыг бэлэн жагсаах | IX/21 | 1.Аймгийн ЗДТГ-ын албан хаагчид, 2.ХХААГ |
| 8 | | Нээлтэд оролцох, үг хэлэх, мэндчилгээ дэвшүүлэх албан тушаалтнуудыг бэлтгэх, мэдээлэл хүргэх | | Соёл урлагийн газар |
| 9 | "Эрдэнэт сүргийн эзэд-1000 чуулган" | Чуулганы хөтөлбөр, шторик бэлтгэх, олон нийтэд мэдээллэх | IX/8-20 | 1.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, 2.Цахим үйлчилгээний хэлтэс |
| | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 10 | | Чуулганы тайз засах, техник хэрэгсэл бэлтгэх | IX/20 | 1.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, 2.Цахим үйлчилгээний хэлтэс, 3.Нийгмийн бодлогын хэлтэс, 4.Соёл урлагийн газар 5.Биеийн тамир спортын газар |
| 11 | | Спорт цогцолборт сандал байршуулах | IX/18 | 1.Нийтлэг үйлчилгээний алба, 2.Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс,3. Цэргийн штаб, 4.Биеийн тамир спортын газар |
| 12 | | Спорт цогцолборт сумдын нэр хаяг байршуулах | IX/18 | 1.Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, 2.Санхүү төрийн сангийн хэлтэс, 3.Архивын тасаг |
| 13 | | Спорт цогцолборын орох гарах хаалгуудад хөтөч хийх | IX/22 | Хуваарийн дагуу |
| 14 | | Цэвэр ус байршуулах /Чуулганы цагаар/ | IX/22 | Хуваарийн дагуу |
| 15 | | Чуулганд тавих "Малчдын талаар баримтлах бодлогын баримт бичиг"-ийн төсөл бэлтгэх, танилцуулах | IX/13 | 1.АЗДТГ-ын дарга 2.Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, 3.Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| 16 | | Нийгмийн салбарын илтгэл бэлтгэх, танилцуулах | IX/13 | Нийгмийн бодлогын хэлтэс |
| 17 | | Хөдөө аж ахуйн, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн талаар илтгэл бэлтгэх, танилцуулах | IX/13 | Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс |
| 18 | | Төрийн одон медаль гардуулах ёслолын ажиллагаа бэлтгэх | IX/20-22 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| 19 | Хүндэтгэлийн шоу цэнгүүн | Талбай тайз засах | IX/21 | Нийтлэг үйлчилгээний алба, соёл урлагийн газар |
| 20 | | Хөтөлбөр бэлтгэх, танилцуулах | IX/13 | Соёл урлагийн газар |
| 21 | | Олон нийтэд зар, мэдээлэл хүргэх, сурталчлах | IX/08-24 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| 22 | | Салют буудлага бэлтгэх | IX/22 | 1.Онцгой байдлын газар 2.Биеийн тамир спортын газар |
| 23 | Эмчийн үзлэг | Эмчийн үзлэгийн байр бэлтгэх, хянуулах | IX/18 | 1.Нийгмийн бодлогын хэлтэс, 2.Эрүүл мэндийн газар 3.Биеийн тамир спортын газар |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 24 | Соёл урлагийн арга хэмжээ, уралдаан | Урлаг, спортын арга хэмжээ зохион байгуулах байр талбай, заалны бэлэн байдалд хяналт тавих | IX/18 | 1.Т.Норов 2.Д.Энхжаргал 3.П.Отгонбаяр 4.Г.Энхбаяр 5.Б.Оюунбаатар |
| 25 | | Уралдаан зохион байгуулах байр, тайз, техник хэрэгсэл бэлтгэх | IX/20 | Соёл урлагийн газар /Хөгжимт драмын театр, тэмүүжин театр/ |
| 26 | | Урлаг, спортын төрлүүд болох театр, заал талбайн мэдээллийг сумдад хүргэх | IX/18 | Сумдууд хариуцсан албан хаагчид |
| 27 | | Уралдааны эцсийн дүн мэдээг авах, нэгтгэх | IX/24 | Томилогдсон ажлын хэсэг /Д.Сарангарав, Т.Хишигбааттар, У.Балжинням, Б.Оюунбаатар, Б.Пүрэвдагва |
| 28 | Спортын 7 төрөлт тэмцээн | Спортын тэмцээнүүд зохион байгуулах заал, талбай, шүүгчийг бэлтгэх | IX/18 | Биеийн тамир спортын газар |
| 29 | | Шагнал урамшил бэлтгэх, хариуцах | IX/22-24 | Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс |
| 30 | "Нүүдэлчин фестиваль"-д оролцсон Шашин урлагийн цэнгүүн | Талбай тайз засах | IX/22 | Нийтлэг үйлчилгээний алба, соёл урлагийн газар |
| 31 | | Хөтөлбөр бэлтгэх | IX/13 | 1.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 2.Соёл урлагийн газар |
| 32 | Хаалтын үйл ажиллагаа-"Гала тоглолт" | Талбай тайз засах | IX/23 | Нийтлэг үйлчилгээний алба, соёл урлагийн газар |
| 33 | | Хөтөлбөр бэлтгэх | IX/23 | 1.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс 2.Соёл урлагийн газар |
| 34 | Нээлттэй өдөрлөг зохион байгуулах | Байгууллагуудад мэдээлэл хүргэх | IX/08-22 | 1.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, 2.Хууль эрх зүйн хэлтэс 3.Нийгмийн бодлогын хэлтэс |
| 35 | | Нээлттэй өдөрлөг зохион байгуулах байр бэлтгэх | IX/18 | |
| 36 | Баялаг бүтээгч-Баянхонгор | Байр талбай засах, оролцогчдод мэдээлэл хүргэх, бүртгэх, зохион байгуулах | IX/18-21 | 1.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал 2.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс ,3.Хүнс, хөдөө аж ахуйн газар, 4.Баянхонгор сумын ЗДТГ |
| 37 | Хэвлэл | Эх бэлтгэл | IX/08-10 | 1.Цахим үйлчилгээний хэлтэс 2.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс |
| 38 | | Анонос байршуулах | IX/09-12 | 1.Цэргийн штаб, 2.Биеийн тамир спортын газар 3.Нийтлэг үйлчилгээний алба, 4.Хүнс хөдөө аж ахуйн газар, 5.Онцгой байдлын газар |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 39 | Оролцогчдын мэдээлэл | Чуулган, урлаг, спортын тэмцээнд оролцогчдын мэдээллийг нэгтгэж, холбогдох газруудад хүргэх | IX/18 | 1.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, 2.Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| 40 | Танилцах аялал зохион байгуулах | Чуулганд оролцогчдод орон нутгийн бүтээн байгуулалтыг танилцуулах аяллыг 2023.09.22,23,24-ны өдрүүдэд зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, танилцуулах хөтөлбөрийг танилцуулах | IX/13 | |
| 41 | Чуулганы тайлан нэгтгэх | Чуулганы тайлан, тусгай төрлийн баримтыг нэгтгэн архивт хүлээлгэн өгөх | | |

____________оОо_____________

Аймгийн Засаг даргын 2023 оны
09 дүгээр сарын 07-ны өдрийн
А/487 дүгээр захирамжийн дөрөвдүгээр хавсралт

МАЛЧДЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Зардлын нэр | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Эмчийн үзлэг | | | **2 000 000** |
| 2 | Үдийн хоол /1 дэх өдөр/ | 1000 | 10000 | 10 000 000 |
| 3 | Үдийн хоол /2 дахь өдөр/ | 1000 | 10000 | 10 000 000 |
| 4 | Үдийн хоол /2 дахь өдөр/ | 1000 | 10000 | 10 000 000 |
| 5 | Цэвэр ус | 2000 | 600 | 1 200 000 |
| 6 | Нээлт хаалтын үйл ажиллагааны зардал | | | **1 800 000** |
| 7 | | | | **35 000 000** |

___________oOo__________